



МОНГОЛБАНК АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байр: Эдийн засагч – 2

Ажиллах газар: Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэст

Тавигдах шаардлага:

- Эдийн засаг, банк санхүү, статистик болон математик загварчлалын чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй;
- Эконометрик болон эдийн засгийн онолын загваруудын талаар суурь мэдлэгтэй;
- Оффисийн болон статистикийн програм хангамжийг сайн эзэмшсэн;
- Шуурхай, ажлын эрч хүчтэй, цаг барьдаг;
- Англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн;
- Багаар ажиллах чадвартай;
- Цаашид уг ажлын байран дээр мэргэшиж, тогтвор суурьшилтай ажиллах эрмэлзэлтэй.

Бүрдүүлэх материал:

- Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар;
- Дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан/;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Өмнө нь ажиллаж байсан бол тухайн байгууллагын тодорхойлолт.

Шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн Монголбанкны Төв байрны бичиг хэрэгт авчирч өгнө үү.

Материал хүлээн авах эцсийн хугацаа: 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр.

Ирүүлсэн материалыг буцаахгүй бөгөөд өргөдлийн материалын шаардлага хангасан хүмүүсийг бичгийн шалгаруулалтад оруулна. Бичгийн шалгалт нь дунд түвшний макро эдийн засгийн онол, эконометрикс болон төлбөрийн тэнцлийн статистикийн талаарх асуулт, бодлогууд мэргэжлийн англи хэлний орчуулга байх болно.

Жич: Харилцах утас, холбоо барих хаягаа төрийн албан хаагчийн анкетад тодорхой бичнэ үү.

Нэмэлт мэдээллийг 318624, 327088, 323243 утсаар холбогдон авна уу.

МОНГОЛБАНК